



**БУЛГАН АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ**

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар A/182

Булган

Г Гүйцэтгэгчид гэрээ байгуулах  
эрх олгох тухай Г

Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2 дахь заалтыг үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1. Байгаль хамгаалах сангийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих төсөл арга хэмжээнд тусгагдсан Байгаль хамгаалагчдын иж бүрэн хувцас /30 ширхэг/ нийлүүлэх нийлүүлэгчийг сонгон шалгаруулах үнэлгээний хорооны 2019 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн хурлын зөвлөмжийн дагуу дээрх ажлыг гүйцэтгэх гүйцэтгэгчээр Булган аймгийн “Хурмастын хүлэг” ХХК-ийг сонгож 28 950 000 /хорин найман сая есөн зуун тавин мянга/ төгрөгөөр гэрээ байгуулах эрхийг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т олгосугай.

2. Дээрх барааг нийлүүлэх нийлүүлэгчтэй холбогдох хууль, тогтоомжийн хүрээнд гэрээ байгуулж, гүйцэтгэлд хяналт тавьж, хүлээн авахыг аймгийн Байгаль, орчин аялал жуулчлалын газар /А.Гантөмөр/-т даалгасугай.

3. Гэрээний хугацаанд холбогдох хууль, журам, стандартын дагуу барааг хүлээлгэн өгөхийг “Хурмастын хүлэг” ХХК /Б.Ганзориг/-д үүрэг болгосугай.

4. Тус ажлыг хууль, тогтоомж, гэрээний дагуу Байгаль хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний сангаас санхүүжүүлэхийг нягтлан бодогч /Б.Очирсүрэн/-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА



З.БАТЗОРИГ

20190177